



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

172 /172/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.11.08

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

ОХУ-ЫН БАТЛАН ХАМГААЛАХЫН ОРЛОГЧ САЙД, ХУРАНДАА ГЕНЕРАЛ А.В.ФОМИНТОЙ УУЛЗАВ



Монгол Улсаас ОХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Д.Даваа 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр ОХУ-ын Батлан хамгаалахын орлогч сайд, хурандаа генерал А.В.Фоминтой тус улсын Батлан хамгаалах яаманд нөхөрсөг уулзалт хийв.

Уулзалтаар Элчин сайд Д.Даваа сүүлийн хоёр жилийн хугацаанд нягт хамтран ажилласан явдалд талархал илэрхийлж, хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойн

хүлээн авалтад урьж байгаагаа уламжилсан юм. Мөн 100 жилийн ойн хүрээнд хоёр орны цэрэг, цэрэг-техникийн хамтын ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулсан ОХУ-ын Батлан хамгаалахын орлогч сайд, хурандаа генерал А.В.Фоминийг Монгол Улсын Төрийн өндөр дээд шагнал "Алтан гадас" одонгоор, тус яамны Олон улсын цэргийн хамтын ажиллагааны Ерөнхий газрын дарга, дэслэгч генерал А.А.Кшимовскийг "Найрамдал" медалиар, тус газрын цэрэг-

техникийн буцалтгүй тусламж хариуцсан бүлгийн ахлах I зэргийн ахмад А.А.Мойсеенког "Найрамдал" медалиар тус тус шагнасныг гардуулан өгч, баяр хүргэлээ.

Орлогч сайд, хурандаа генерал А.В.Фомин сүүлийн жилүүдэд Монгол, Оросын цэрэг, цэрэг техникийн хамтын ажиллагаа өндөр түвшинд хөгжиж байгаад сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж, үүнд үнэтэй хувь нэмэр оруулсан Элчин сайд Д.Даваад талархал илэрхийлэв.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

| ӨДӨР | ШӨНӨ |
|------|------|
| -1 | -16 |

ӨМНӨД СУДАН

| ӨДӨР | ШӨНӨ |
|------|------|
| 33 | 21 |

ВАЛЮТЫН ХАНШ

| ВАЛЮТ | АВАХ | ЗАРАХ |
|-------|---------|---------|
| USD | 2,850.0 | 2,853.0 |
| EUR | 3,310.0 | 3,320.0 |
| CNY | 445.00 | 446.50 |
| RUB | 40.00 | 40.80 |
| JPY | 24.90 | 25.20 |
| KRW | 2.39 | 2.40 |

ЗУРХАЙ

2021.11.08 ДАВАА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 04/

ӨВЛИЙН ТЭРГҮҮН ШАРАГЧИН ГАХАЙ САРЫН ХОЁР ХАР ЦАГААН БИЧ ӨДӨР

Үс засуулбал:

Бие эрхтний хүч сайжирна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 07.48-17.24

Барилдлага:

Рашаан

Шүтэн барилдлага:

Хуран үйлдэхүй

Суудал:

Гал

Аргын тооллын 11 сарын 8, Сумъяа гараг. Билгийн тооллын 4, Гар одтой, цагаан бич өдөр. Өдрийн наран 7 цаг 48 минутад мандан, 17 цаг 24 минутад жаргана. Тухайн өдөр хулгана, луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр эм, эмнэлгийн элдэв үйл, хагалгаа хийлгэх, биеийн тамырыг сэргээх, хараал, жатхыг буцаах, бүжиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, урлан бүтээхэд сайн. Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одоогод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал бие эрхтний, хүч сайжирна.

МОНГОЛ БАХАРХЛЫН ӨДӨРТ ЗОРИУЛСАН “ЭХ ТҮҮХИЙН ЖИМЭЭР” УУЛЗАЛТ БОЛЛОО

Монгол Улсад 2012 оноос бүх нийтийн амралтын өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлж буй Монгол бахархлын өдөр өнгөрсөн Баасан гаригт тохиолоо. Тэгвэл тус өдрийг тохиолдуулан Монгол цэргийн музей “Эх түүхийн жимээр” уулзалтыг зохион байгууллаа. Энэхүү уулзалтад Монгол цэргийн музейн удирдлага, ажилтан албан хаагчид, “Эх түүхийн жимээр” нэвтрүүлгийг санаачлагч, ШУТИС-ийн БХУС-ийн хүмүүнлэгийн салбарын ахлах багш, түүхийн ухааны доктор М.Жавзансүрэн болон Тэмүжин Өрлөг сургуулийн ахлах ангийн сурагчид оролцсон юм.

Тус музейн захирал, хурандаа Д.Ганзориг хүндэтгэлийн үг хэлснээр уулзалт албан ёсоор эхэллээ.

Тэрээр Их эзэн Чингис хааны мэлмий гийсэн өдөр буюу Монгол бахархлын өдрийн онцлог, ач холбогдлын талаар сонирхолтой лекц уншиж, сурагчдын сонорыг мялаав. Түүнчлэн Соёлын яамнаас зарласан “Соёлын бүтээлч сар” ажлын хүрээнд үзэгч олон, хүүхэд залууст эх оронч үзэл төлөвшүүлэх, эх түүхийн мэдлэг боловсрол олгох зорилгоор энэхүү уулзалтыг зохион байгуулсан гэдгийг онцолсон юм. Мөн лабораторийн эрхлэгч-археологич Э.Түвшин музейн түүх, үйл ажиллагаа, дэвшүүлсэн зорилго, зорилтыг танилцууллаа.

Үүний дараа түүхийн ухааны доктор М.Жавзансүрэн анхны



түүхийн онлайн телевизийнхээ тухай танилцуулж, эх орон дархан хил, хилчин дайчдын аж амьдрал, ажил хөдөлмөрийг сурталчлан таниулсан “Эх түүхийн жимээр” нэвтрүүлгийн санаа анх хаанаас төрсөн, өнгөрсөн хугацаанд хэрхэн яаж хөдөлмөрлөсөн, ямар саад бэрхшээл тулгарч байсан талаараа лекц уншив.

Уулзалтын төгсгөлд түүнтэй цөөн хором ярилцлаа.

М.Жавзансүрэн: БИ МОНГОЛЫНХОО ТҮҮХЭЭР СЭЛЖ БАЙНА
Уулзалтын талаар сэтгэгдлээ

хуваалцахгүй юу? Сурагчид их талархалтай хүлээж авлаа шүү дээ ...

-Түүхийн жимээр нэвтрүүлгийн санаачлаад хөтөлж, найруулж эхэлснээс хойш 5 жил өнгөрсөн байна. Энэ 5 жилийн хугацаанд хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд ярилцлага өгч байсан. Яг өнөөдрийнх шиг хүүхдүүдэд зориулж лекц уншиж байсангүй. Ингээд анх удаа лекц уншихад сэтгэл хөдөлж, хоолой бага зэрэг зангирлаа. Яагаад гэвэл миний эхлүүлсэн энэ ажлын зам нь өөрөө их бартаатай хүнд байлаа. Монгол хүнийхээ хувьд бид бахархалтай байх ёстой. Тэр нь юу байх вэ. Эх орноороо, эх түүхээрээ,

монгол хүн болж төрснөөрөө бахархах учиртай. Энэ хүүхдүүд үндсэрхэг биш үндэсний үзэлтэй байх нь чухал юм. Үүний үлгэр дуурайллыг эгэл жирийн багш эмэгтэйдээ олж харсан болов уу гэж бодож байна. Түүнээс биш ийм төрлийн нэвтрүүлгүүд олон байдаг шүү дээ. Хэр олон хүнд хүрч, талархал хүлээхдээ гол нь бус түүхийг ирээдүй хойч үедээ яаж өвлүүлж чадах вэ гэдэг санаа, зорилго л нэн тэргүүний асуудал юм.

(Үргэлжлэл нь II нүүрт)

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

| | | |
|----------------------------------|---------------------|-------------------------|
| НИЙТ БҮРТГЭГДСЭН 357,888 +789 | ЭДГЭРСЭН 535,826 | НАС БАРСАН 1,653 +12 |
|----------------------------------|---------------------|-------------------------|

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

| | | |
|------------------------------|----------------------------|------------------|
| НИЙТ БАТЛАГДСАН 6195 +106 | ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 153 | ЭДГЭРСЭН 5922 |
|------------------------------|----------------------------|------------------|

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

| |
|--------------------------------|
| Тохиолдол Нийт: 250,597,519 |
| Эдгэрсэн Нийт: 226,830,764 |
| Нас барсан Нийт: 5,064,450 |

ВАКЦИНЖУУЛАЛТ /НИЙТ ХҮН АМ/

I тун: 2,256,066 (69,3%)

II тун: 2,141,276 (65,8%)

Дархлаа сэргээх тун: 444,279 (14.0%)

Иргэн Та амны хаалтаа тогтмол зүүж, дархлаа сэргээх нэмэлт тунд хамрагдсанаар өөрийгөө болон гэр бүлээ КОВИД-19-ийн халдвараас хамгаална.

ЦАХИМ ШУУДАНД

Зэвсэгт хүчний 032 дугаар анги

ЕСӨН ХӨЛТ ЦАГААН ТУГАА ЦЭНГҮҮЛЛЭЭ



Чингис хаан Их Монголын тулгар төрөө байгуулж есөн хөлт, есөн хэлт, есөн манжлагат төрийн Их цагаан сүлдийг босгон тахиснаас эхлэн өнөөг хүртэл онголон шүтэн дээдэлж ирсэн түүхтэй. Өдгөө төрийн торгон цэрэг, хүндэт

харуулын бүрэлдэхүүн Их эзэн Чингис хааны мэндэлсэн өдөр буюу Монгол Бахархлын өдрөөр Монгол Улсын төр өнө мөнхөд мандан бадарч, төр улс, түмэн олон амар түвшин аж төрөхийн бэлгэдэл болсон Төрийн их Есөн хөлт цагаан тугаа цэнгүүллээ.

ЖУКОВЫН ХӨШӨӨНД ЦЭЦЭГ ӨРГӨВ



Монгол Улс, ОХУ-ын дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойг тохиолдуулан олон ажил төлөвлөсний нэг нь ЗХУ-ын 4 удаагийн баатар, Монгол Улсын баатар Георгий Константинович

Жуковын хөшөөнд цэцэг өргөх хүндэтгэлийн арга хэмжээ байсан юм. Цэцэг өргөх ёслолын ажиллагаанд Хүндэт харуулын бүрэлдэхүүн, үлгэр жишээ үлээвэр найрал хөгжимтэй жагсаж хүндэтгэл үзүүлээ.

Ахмад О.ГЭРЭЛЗАЯА

САРЫН АЯНЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ

Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа 457 дугаар хорих ангиас санаачилсан Ховд аймгийн төрийн цэргийн байгууллагуудын дунд "Төрийн цэргийн байгууллагын алба хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх" аяны хүрээнд тусгай төлөвлөгөө боловсруулан Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа Б.Ганхуяг болон Төрийн цэргийн байгууллагын удирдлагуудаар батлуулан 2021 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулж явуулахаар сарын аяны нээлтийг хийлээ.

Сарын аяны нээлтийн үйл ажиллагаанд аймгийн Засаг дарга Б.Дүгэржав, Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболд, Цэргийн штабын дарга, хурандаа Б.Ганхуяг болон төрийн цэргийн байгууллагын удирдлага, алба хаагчид оролцов.

Зөвлөгөөнийг нээж аймгийн Засаг дарга Б.Дүгэржав хэлсэн үгэндээ "Төрийн алба хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг

дээшлүүлэхэд манай аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн цэргийн байгууллагууд санаачилга гарган ажиллаж байгаад сэтгэл өндөр байна. Манай аймаг төрийн албаны хувьд "Соёлтой төрийн үйлчилгээ-Авлига хүнд сурталгүй аймаг болох" зорилт дэвшүүлэн "Хариуцлагатай тунгалаг төр" хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа. Үүний нэг илрэл нь төрийн цэргийн байгууллагын алба хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх сарын аян юм. Иймд төрийн тусгай алба хаагч та бүхнээс төрийн алба хаагчийн эрхэмлэх 9 зүйл, ёс зүйг сахин, сахилга хариуцлагаа өндөржүүлж аяндаа идэвхтэй хамрагдахыг уриалж байна" хэмээн аяны үйл ажиллагааг дэмжиж байгаагаа илэрхийлсэн.

Төлөвлөгөөнд "Сахилга хариуцлагыг дээшлүүлэх зөвлөгөөн", "Аянд хамрагдаж байгаа байгууллагын алба хаагчдаас зөрчлийн тухай хуулиар шийтгэгдсэн эсэх талаар мэдээлэл хийх", "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх", "Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм", "Цэргийн жагсаалын дүрэм",

"Батлан хамгаалах чиглэлээр гарсан хууль тогтоомж, түүний хэрэгжилтийг хангахад Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үүрэг бүхий байгууллагуудыг оролцоо" зэрэг сургалт зохион байгуулах, "Ёс журмын эргүүл томилон ажиллуулах" гэсэн ажлуудыг тусгасан юм.

Төлөвлөгөөний дагуу 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр төрийн цэргийн байгууллагын алба хаагчдын төлөөллийг хамруулсан "Сахилга хариуцлагыг дээшлүүлэх зөвлөгөөн"-ийг Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар хорих анги хамтран зохион байгуулж явууллаа.

Мөн Ховд аймаг дахь төрийн цэргийн байгууллагын удирдлагууд илтгэл хэлэлцүүлж, мэдээлэл хийн зөвлөгөөний төгсгөлд зөвлөгөөнд оролцогчдоос санал сонссоны зэрэгцээ Цэргийн штабын дарга, хурандаа Б.Ганхуяг аяны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг бие бүрэлдэхүүнд танилцуулав.

Хошууч Д.ТАМИР

9.9 САЯ ТӨГРӨГИЙН ӨРТӨГ БҮХИЙ ХИВСТЭЙ БОЛЛОО



Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Хэнтий аймгийн Засаг даргаар ажиллаж байх үедээ Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн удирдлагаас тавьсан "Чингис цэргийн хүрээ"-ний хүндэт харуул жагсах

үед хэрэглэгдэх хивс олгуулах хүсэлтийг шийдвэрлэж, "Эрдэнэт хивс" үйлдвэрт 1.5 м өргөнтэй 96 метр гудмын хивс, 1.6x2.4 хэмжээтэй 4 ширхэг хивсийг 9.9 сая төгрөгөөр захиалан авч гардуулан өглөө.

"ЭХ ОРОН, ЭР ЦЭРГИЙН АЛБА" ӨДӨРЛӨГӨӨР ...



Байлдааны гавьяаны Улаан тугийн одонт, Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит Зэвсэгт хүчний 336 дугаар анги Монгол бахархлын өдрийг тохиолдуулан шинэ дайчдад Зэвсэгт хүчинд ашиглагдаж буй

зэвсэглэл, техник, хугацаат цэргийн алба хаагчдын ахуй хангалт, хувцас, хүнсний нормыг танилцуулсан өдөрлөг зохион байгууллаа.

Дэд хурандаа Н.Эрдэнэбаяр

МОНГОЛ БАХАРХЛЫН ӨДӨРТ ЗОРИУЛСАН "ЭХ ТҮҮХИЙН ЖИМЭЭР" УУЛЗАЛТ БОЛЛОО



(Түрүүч нь I нүүрт)

Хилийн цэргийн олон анги, отрядуудаар явсан хүнээс эх орон, эх оронч үзлийн талаар асуухгүй өнгөрч болохгүй нь ...

-Би түүхийн багш. Түүх заахдаа оюутнуудад хэлдэг юм. Эх оронч байхыг УИХ-д гарах, сайд дарга болж албан тушаалд хүрнэ гэдгээр хязгаарлаж ойлгож болохгүй. Үүрэгт ажилдаа чин сэтгэлээсээ хандах энэ хандлагаас л эхэлнэ. Эх орон хаанаас эхлэх вэ. Унасан газар угаасан уснаас. Төрсөн газар, төрөлх сургуулиа хайрлаж сурсан цагт эх орон гэж ярьж эхэлнэ гэж боддог. Сургуулийнхаа үүдэнд шүлсээ хаяхгүй, хогоо хаяхгүй, ойр орчмыг бохирдуулахгүй байх энэ хандлагаас бүх зүйл эхэлнэ. Цэцэрлэг, сургуульд боловсорч байхад нь л эх орноо хайрлах энэ үзэл, хандлагыг

төлөвшүүлэх хэрэгтэй. Хүүхэд бүрд эх орон гэж юу болохыг энгийн зүйлээс эхлээд ойлгуулах нь хамгийн чухал гэж бодож байна. Бид хүүхдэд хэт томоор төсөөлөх сэдэл төрүүлээд байдаг. Энэ нь буруу.

Таны санаачилсан "Эх түүхийн жимээр" нэвтрүүлэг цаашид үзэгч олон нийтэд хэрхэн яаж хүрэх вэ?

-21 аймгийнхаа бүх сумдыг дуусгахаар зорьж байна. Хамгийн ойр төлөвлөсөн зүйл гэвэл Увс, Хөвсгөл аймгийн бүх суманд очно. Одоогоор хэд хэдэн сумдад хүрч очсон байгаа. Ингээд 21 аймгийн бүх сумдад очсоны дараа Дэлхийн монгол судлалаар явах төлөвлөгөөтэй байна. Монголын түүх агуу. Энэ агуу түүх рүү ганц эмэгтэй хүн ороод сэлж байгаа гэж ойлгож болно. Мөлжөөд барахгүй ийм өргөн агуулгатай сэдэв шүү дээ. Би амьсгалж, оршиж байгаа цагт явсаар л байх болно.

Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)